



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/ЧБЗ

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 14,330,596.0 /арван дөрвөн сая гурван зуун гучин мянга таван зуун ерэн зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /Э.Энхзаяа/-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 885,797.0 /найман зуун наян таван мянга долоон зуун ерэн долоон/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 14 нэр төрлийн нийт 13,444,799.0 /арван гурван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга долоон зуун ерэн есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /Э.Энхзаяа/-д үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдалгын газрын  
даргын 2020 оны 09 дүгээр сарын 30 ний өдрийн  
1183 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

№	Эд хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	нэгж үнэ	бүгд үнэ	хур.элэгдэл	Үлдэх өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	принтер А-3	2010	ш	1	560,000.0	560,000.00	560,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
2	ipad-2	2012	ш	1	1,400,000.0	1,400,000.00	1,400,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
3	нөөтбүк	2012	ш	1	1,295,484.0	1,295,484.00	1,295,484.00	-	эвдэрсэн	актлах	татах
4	канон принтер	2007	ш	1	1,650,000.0	1,650,000.00	1,650,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
5	компьютер dell	2013	ш	2	1,078,000.0	2,156,000.00	2,156,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
6	компьютер dell	2013	ш	1	848,875.0	848,875.00	848,875.00	-	эвдэрсэн	актлах	татах
7	скайнер	2014	ш	1	1,800,000.0	1,800,000.00	1,800,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
8	усны жижиг аппарат	2014	ш	1	179,990.0	179,990.00	179,990.00	-	эвдэрсэн	актлах	татах
9	камер sony	2014	ш	1	1,800,000.0	1,800,000.00	1,800,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
10	өсгөгч JBL	2007	ш	1	671,550.0	671,550.00	671,550.00	-	эвдэрсэн	актлах	татах
11	тоос сорогч	2015	ш	1	199,000.0	199,000.00	199,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
12	агаар чийгшүүлэгч	2014	ш	1	69,900.0	69,900.00	69,900.00	-	эвдэрсэн	актлах	татах
13	дуу хураагуур	2015	ш	3	198,000.0	594,000.00	594,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
14	зургийн аппарат гэрэл	2015	ш	1	220,000.0	220,000.00	220,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>						<b>13,444,799.00</b>	<b>13,444,799.00</b>	-			
1	эрдэнэт хивс	2006	ш	1	53,428.00	53,428.00	53,428.00	-	эвдэрсэн	актлах	устгах
2	хивс	2006	ш	1	176,509.00	176,509.00	176,509.00	-	эвдэрсэн	актлах	устгах
3	буйдан	2006	ш	1	435,860.00	435,860.00	435,860.00	-	эвдэрсэн	актлах	устгах
<b>Тавилга, эд хогшлын дүн</b>						<b>665,797.00</b>	<b>665,797.00</b>	-			
1	бичиг хэргийн програм	2013	ш	1	220,000.00	220,000.00	220,000.00	-	эвдэрсэн	актлах	устгах
<b>Програм хангамжийн нийт дүн</b>						<b>220,000.00</b>	<b>220,000.00</b>	-			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>				<b>19</b>		<b>14,330,596.00</b>	<b>14,330,596.00</b>				
Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө						13,444,799.00					
Актлах хөрөнгө						885,797.00					